



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/828

Улаанбаатар хот


Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, ИНД-171 "Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллагын үйл ажиллагаа ба гэрчилгээжүүлэлт" дүрмийн 171.53 дугаар зүйлийн "г" заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Иргэний нисэхийн агаарын навигацийн үйлчилгээний тоног төхөөрөмжийг гэрчилгээжүүлэх журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталж, 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Агаарын навигацийн тоног төхөөрөмжүүдийн техникийн баримт бичгүүдийг журмын дагуу бүрдүүлэхийг Техник хангалт, навигацийн үйлчилгээний алба /Д.Баяртогтох/, Оношилгоо хэмжил зүйн лаборатори /Г.Батцэцэг/, Орон нутгийн нисэх буудлуудын дарга нарт, гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулахыг Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтэс /Ё.Эрдэнэбат/-т тус тус даалгасугай.

3. Энэ журам батлагдсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/263 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Л.БЯМБАСҮРЭН

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2016 оны 11 дүгээр сарын 30 ний өдрийн
17828 дугаар тушаалын хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН АГААРЫН НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Иргэний нисэхийн агаарын навигацийн үйлчилгээнд ашиглагдах тоног төхөөрөмжүүд /цаашид "Тоног төхөөрөмж" гэх/-ийг ашиглалтад хүлээн авах, гэрчилгээжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

ХОЁР. ЭРХ ЗҮЙН АКТУУД

2.1. Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ИКАО/-ын Агаарын навигацийн үйлчилгээний тоног төхөөрөмжүүдтэй холбогдолтой (Хавсралт 10, 14, Док 8071) баримт бичгүүд, Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль, Иргэний нисэхийн дүрэм ИНД-171, НААХЗА-ын даргын батлан гаргасан "Нисэхийн системүүдэд тавигдах шаардлагууд" болон тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, заавруудад үндэслэн энэхүү журмыг боловсруулав.

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

3.1. ИНД-171.11 "Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллагын үйл ажиллагаа ба гэрчилгээжүүлэлт" дүрмийн 171.11-д заагдсан үйлчилгээний тоног төхөөрөмжүүдэд ашиглалтад тэнцэх гэрчилгээ олгох ба тэдгээрийн дэд бүтцэд ашиглагдах туслах тоног төхөөрөмжүүдэд бүртгэлийн гэрчилгээ олгоно.

3.1.1. ИНД-171 "Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллагын үйл ажиллагаа ба гэрчилгээжүүлэлт" дүрмийн 171.11-д заагдсан тоног төхөөрөмжүүдээс гадна радарын автоматжуулсан систем болон цаг уурын ажиглалтын автомат системүүдэд ашиглалтанд тэнцэх гэрчилгээ олгоно.

3.1.2. Нисэх буудлын бэлтгэл дизель генераторууд болон AFTN терминалуудад бүртгэлийн гэрчилгээ олгоно.

3.2. Иргэний нисэхийн агаарын навигацийн үйлчилгээний тоног төхөөрөмжийн гэрчилгээжүүлэлт хариуцсан нэгж нь Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтэс байна.

ДӨРӨВ. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

4.1. Гэрчилгээнд хамрагдах тоног төхөөрөмжүүд энэхүү журмын 2.1-д заагдсан хууль тогтоомжуудын шаардлагуудыг хангасан байхаас гадна тухайн тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчээс гаргасан техник ашиглалтын нөхцөл, шаардлагуудыг хангасан байна.

4.2. Чиглэлийн нислэгт ашиглах навигаци болон ажиглалтын тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, үйлчилгээг Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 10 дугаар зүйлийн дагуу зөвхөн Техник хангалт, навигацийн үйлчилгээний алба нь хариуцах нөхцөлд гэрчилгээ олгогдоно.

ТАВ. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВАХ- /commissioning/

5.1. Олноор үйлдвэрлэгддэггүй мөн захиалагчийн хүсэлтээр тохиргоонууд хийгдэж угсрагддаг тоног төхөөрөмжүүдэд Иргэний нисэхийн ерөнхий газраас тавьсан шаардлагууд хангагдсаныг бататгах үүднээс үйлдвэрийн хүлээн авах тест (FAT-factory acceptance test) хийгдсэн байвал зохино.

5.2. Үйлдвэрийн хүлээн авах тестийг Иргэний нисэхийн ерөнхий газрын тоног төхөөрөмжид гэрчилгээ олгох, дүгнэлт гаргах эрх бүхий мэргэжилтэн болон ашиглагч байгууллагын инженер техникийн ажилтнууд гүйцэтгэж, зохих баримт бичигт гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

5.3. Гэрчилгээжүүлэлтэнд хамрагдах тоног төхөөрөмжийг шинээр суурилуулсны дараа ашиглалтад хүлээн авах тест (SAT-site acceptance test) хийгдсэн байна.

5.4. Иргэний нисэхийн ерөнхий газрын холбогдох мэргэжилтэн тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авах дүгнэлт үйлдэхдээ ашиглагч байгууллагын инженер техникийн ажилтнуудын бэлтгэсэн зохих акт, баримт бичгийг үндэслэх ба шаардлагатай гэж үзвэл тоног төхөөрөмжийн ажиллагааг шалгах ажилд биечлэн оролцоно.

5.5. Иргэний нисэхийн радио навигацийн болон бодит ажиглалтын системийн байгууламжид ИКАО-ын Док 8071-д заагдсаны дагуу эрх бүхий байгууллага /~~Нислэгийн журам боловсруулалтын алба~~/ нь газрын үзлэг, шалгалт, тохиргоо, хүлээн авах шалгалтын нислэгийг гүйцэтгэж, дүгнэлт гаргасан байна.

ЗУРГАА. ШИНЭЭР ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ

6.1. Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга эсвэл эрх шилжүүлсэн албан тушаалтан нь гэрчилгээг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох эрх эдэлнэ.

6.2. Өргөдөл гаргагч нь анх ашиглалтад авч байгаа тоног төхөөрөмжид гэрчилгээ авахын тулд дараах материалуудыг жагсаалтын дагуу бүрдүүлэн Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтэст хүргүүлнэ. Үүнд:

- a. Тоног төхөөрөмж ашиглахыг хүсэгчийн өргөдөл /Маягт ТТ-1/
- b. Үйлдвэрийн хүлээн авах тестийн материал
- c. Тухайн байгууламж, тоног төхөөрөмж нь Нисэхийн системүүдэд тавигдах шаардлагын холбогдох заалтуудад бүрэн нийцэж байгааг харьцуулсан хүснэгт хэлбэрээр бататгаж харуулсан материал өргөдөл гаргагчийн дотоод хяналт хариуцсан нэгжийн дүгнэлтийн хамт.
- d. Тоног төхөөрөмжийн газардуулгын хэмжилт, шалгалтыг эрх бүхий байгууллагаар хийлгүүлсэн үр дүнгийн хуудас, акт.

е. Суурилуулсаны дараа ашиглалтад хүлээн авах тестийн материал.
Үүнд:

- Техникийн шалгалт тохируулгыг суурилуулсан газар дээр нь хийж хүлээн авсан акт /эх хувь/
- Эрх бүхий байгууллага /Нислэгийн журам боловсруулалтын алба/-ын тоног төхөөрөмжид хийсэн шалгалтын нислэгийн дүгнэлт /эх хувь/
Радио навигаци ба ажиглалтын системийн тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авах тест нь 2 үе шаттай явагдах ба энэ нь газар дээр ба шалгалтын нислэгээр хийсэн тестээс бүрдэнэ.
- Цаг уурын ажиглалтын автомат тоног төхөөрөмжийн хувьд эрх бүхий байгууллагаар хийлгүүлсэн хэмжилт, тохируулга хийсэн акт, дүгнэлт

f. Тоног төхөөрөмжийг хүлээн авах техникийн дүгнэлт /Маягт ТТ-2/ Өргөдөл гаргагч байгууллагын хариуцсан нэгж (ИНЕГ-ийн харьяа байгууллагуудын хувьд дотоод хяналт хариуцсан нэгж)-ийн ажилтнууд гаргана.

g. Техник ашиглалтын заавар /орос, англи хэл дээр байж болно/.

h. Төхөөрөмжийн үйлчлэх алслалтыг харуулсан график буюу долгионы тархалтын зураг. /Газрын зураг дээр байж болно/

i. Тоног төхөөрөмжийн байрлалын уртраг, өргөрөг, (градус.минут.секунд.доль), түүнд хүрэх автозамыг тусгасан газар зүйн байршлыг тодорхойлсон зураг.

j. Холбооны станцын нэвтрүүлэгч ба навигацийн төхөөрөмжүүдийн давтамжийн зөвшөөрлийг эрх бүхий төрийн байгууллагаас авсан байх.

k. ИНЕГ-аас байгууламж, тоног төхөөрөмжийн дуудлага, таних тэмдгийг авсан байх.

6.3. Хувийн хэвшлийн нисэх буудал нь энэ журмын 3.1 ба 3.2-т заагдсан тоног төхөөрөмжүүдийг ашиглах гэрчилгээг авах болон сунгахад шаардлагатай дүгнэлтүүдийг гаргуулахдаа Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтэст хүсэлт гарган холбогдох мэргэжилтнүүд, ажилтнууд, шаардлагатай бол ажлын хэсэг томилуулан шийдвэрлүүлж болно.

6.4. Хэрэв тоног төхөөрөмж нь олон хэсгээс бүрдэж, нэг төрлийн үйлчилгээ үзүүлэх бол тухайн төхөөрөмжид нэг гэрчилгээ олгоно.

6.5. Өргөдөл гаргагчаас ирүүлсэн материалын бүрдэлтэд Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтэс нь хяналт тавьж дүгнэлт гаргаснаар энэхүү журмын 6.1-д заасны дагуу гэрчилгээ олгогдоно.

6.6. Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтэс нь тоног төхөөрөмжийн гэрчилгээг олгосон даруйдаа нисэхийн мэдээлэл хангалт хариуцсан байгууллагын тоног төхөөрөмжийн мэдээний маягтыг бөглөн хүргүүлнэ.

6.7. Шинээр олгогдож байгаа холбоо, навигаци ба ажиглалтын тоног төхөөрөмжийн ашиглалтад тэнцэх гэрчилгээний хугацаа нь тухайн байгууламж,

тоног төхөөрөмжийн зориулалт, ашиглалтын нөхцөл болон гарсан дүгнэлтүүдийг үндэслэн 5 жил хүртэл байж болно.

6.8. Цаг уурын ажиглалтын автомат тоног, төхөөрөмжийн хувьд ашиглалтанд тэнцэх гэрчилгээний хугацаа нь тухайн байгууламж тоног төхөөрөмжийн зориулалт, ашиглалтын нөхцөл болон гарсан дүгнэлтүүдийг үндэслэн 1 жил хүртэлх хугацаатай олгогдоно.

6.9. 171.11.а.1/, 21,3/ -д заагдсан тоног төхөөрөмжийн хувьд ашиглалтын шаардлага хангаж буй хугацаагаар олгогдоно.

6.10. Тоног төхөөрөмжийн бүртгэлийн гэрчилгээний хүчинтэй хугацаа нь тус төхөөрөмжийн ашиглалтын хугацаагаар тодорхойлогдох ба 10-15 жил байна.

ДОЛОО. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАЖ ЭХЛЭХ

7.1. Шинээр олгогдсон тоног төхөөрөмжийн гэрчилгээг үндэслэн ИНЕГ-ын даргын тушаалаар тоног төхөөрөмжийг нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж эхэлнэ.

7.2. Тоног төхөөрөмжийг ашиглаж эхлэх хугацааг олон улсын иргэний нисэхийн байгууллагын AIRAC-ын журмын дагуу тогтооно.

НАЙМ. ГЭРЧИЛГЭЭГ СУНГАХ

8.1. Гэрчилгээг Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтэс эсвэл түүнийг орлох эрх бүхий этгээд сунгана.

8.2. ИНД-171 "Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллагын үйл ажиллагаа ба гэрчилгээжүүлэлт" дүрмийн 171.11.а.4/, 5/ болон энэ дүрмийн 3.2-т заагдсан тоног төхөөрөмжийн гэрчилгээний хүчинтэй хугацааны сунгалт нь тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал, гарсан дүгнэлтүүдээс шалтгаалан 6 сараас 3 жил хүртэл байж болно.

8.3. Гэрчилгээний хугацаа дуусахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө зөвхөн ТТ-2 маягыг бөглөж, Гэрчилгээний эх хувь, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагаар шалгалт тохируулга хийлгүүлсэн актын хамт ирүүлж энэхүү журмын 8.1-д заасны дагуу сунгуулна.

8.4. Ирүүлсэн материалыг үндэслэн тоног төхөөрөмжийн ашиглалтын нөхцөл, хэмжилтийн параметруудийг харгалзан үзэж сунгалтыг гүйцэтгэнэ. Шаардлагатай бол шалгалтын нислэг, газрын хэмжилтийг гүйцэтгүүлэх ба тэдгээрийн тайланг үндэслэн сунгалтыг хийнэ.

8.5. Орон нутгийн нисэх буудалд харьяалагдах тоног төхөөрөмжийн гэрчилгээг тухайн нисэх буудалд нэгдсэн хэлбэрээр тоног төхөөрөмж хариуцсан инженер техникийн ажилтан, Улаанбаатарт байрлах тоног төхөөрөмж болон байгууламжийн гэрчилгээг тухайн тоног төхөөрөмж хариуцсан нэгж тус тус хадгална.

8.6. Тоног төхөөрөмж болон байгууламжид гэрчилгээний хуулбарыг заавал байрлуулна.

ЕС. ГЭРЧИЛГЭЭНИЙ ШИЛЖИЛТ

9.1. Тоног төхөөрөмжүүдийн шилжилт хөдөлгөөн хийгдсэн үед Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтэсээс шийдвэрлэсний дагуу орон нутгийн нисэх буудлын дарга болон Тоног төхөөрөмжийн гэрчилгээ эзэмшигч байгууллагын дарга нар Гэрчилгээний "Тоног төхөөрөмжийн байршил" хэсэгт шилжилтийн хөтлөлтийг хийнэ.

9.2. Навигаци болон ажиглалтын тоног төхөөрөмжүүдийн хувьд 6.2-ын d, e заалтууд заавал хийгдсэн байна.

АРАВ. ГЭРЧИЛГЭЭГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

10.1. Доор заагдсан нөхцөлүүдийн аль нэг нь биелэгдээгүй тохиолдолд гэрчилгээг олгохгүй. Үүнд:

- a. Дагалдах баримт бичиг бүрэн бус,
- b. Техникийн өгөгдөхүүнүүд, байршил /эсвэл төлөвлөлт/ энэхүү журмын 4-р заалтад нийцэхгүй,
- c. Техникийн тасралтгүй ажиллагаа хангагдаагүй,
- d. Ашиглалтын хугацаа, хязгаарлалтууд зохих тушаал заавруудад нийцэхгүй г.м

АРВАН НЭГ. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

11.1. Тоног төхөөрөмжийн ашиглалтад тэнцэх гэрчилгээ аваагүй болон гэрчилгээний сунгалт хийх хугацааг шалтгаангүйгээр хожимдуулсан, тоног төхөөрөмжийн шилжилт хийгдсэн талаар тэмдэглэгээ хийгээгүй тохиолдолд хариуцсан ажилтан, нисэх буудлын дарга, албаны дарга нарт холбогдох хууль, тушаал, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАГЧИЙН ӨРГӨДӨЛ № ...

1. Тоног төхөөрөмжийн маяг, загвар: _____
 2. Үйлдвэрлэгч, улс: _____ үйлдвэрийн дугаар _____
 3. Үйлдвэрлэсэн огноо: _____ Ашиглалтад орсон огноо: _____
 4. Зориулалт: _____
 5. Урьд нь бүртгэлтэй эсэх: Тийм: Үгүй:
 Байсан бол хаана ямар бүртгэлтэй (улс, бүртгэлийн дугаар): _____
 6. Өргөдөл гаргагчийн нэр, албан ёсны хаяг, утас, факс: _____
 7. Албан тушаал: _____
 8. Тоног төхөөрөмж эзэмшигчийн нэр хаяг: _____

 - Хувь хүн бол эзэмшигчийн иргэний үнэмлэхний дугаар: _____
 - Хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: _____
 9. Хамтран эзэмшигч байгаа бол нэр, хаяг: _____

 10. Тоног төхөөрөмжийн радиодолгионы цацаргах хэлбэр, шаардлагатай үелзэл, хүчин чадал

 11. Антены байгууламжийн маяг, газардуулга:

 12. Тоногтөхөөрөмжийг байрлуулах газар зүйн байршил, уртраг, өргөрөг:

 13. Холбооны станцын тохиолдолд дуудлага, (call sign):

 14. Ашиглалтад авч байгаа баримтын дугаар, огноо: _____
 15. Тоног төхөөрөмжийн ажиллах цагийн хуваарь: _____
 16. Цахилгаан хангалт (Тэжээлийн эх үүсвэр-үндсэн, бэлтгэл мотор агрегат, аккумулятор марк загвар):

 17. Даатгалтай эсэх (хаана ямар төрлийн): _____
- Өргөдөл гаргасан: _____ / _____ Огноо: _____
 (гарын үсэг) (овог нэр)

Өргөдөл гаргахад дараах баримтуудыг хавсаргана.

1. Урьд нь аль нэг улсын бүртгэлтэй байсан бол бүртгэлээс хасуулсан тухай баримт
 2. Тоног төхөөрөмжийн эзэмшигч болохыг гэрчилсэн баримт, өмчийн тодорхойлолт
 3. Тоног төхөөрөмжийн техникийн паспорт, дагалдах бусад баримт бичиг
 4. Техник үйлчилгээний заавар мөн техник ашиглалтын паспорт
 5. Тоног төхөөрөмжийн ажиллагааны алслалт харуулсан график зураг (цар хүрээний тархалтын газар зүйн зураг, холбоо, навигаци ашиглаж болох өндөр зайны өгөдөхүүнийг харуулсан график)
 6. Газар дээр шалгалт тохируулга хийсэн акт буюу баримт бичиг
 7. Тоног төхөөрөмж байрлуулах газар зүйн байршлын план, тус газарт хүрэх машин болон замын зураг.
 8. Шалгалтын нислэгийн акт буюу дүгнэлт
 9. (Шалгалтын нислэгээр баталгаажуулсан тоног төхөөрөмжид хамааралтай)
- Өргөдөл хүлээн авсан огноо _____ (гарын үсэг)

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКИЙН ДҮГНЭЛТ

Байгууллагын нэр, хаяг: _____

Дараах бүрэлдэхүүнтэй: _____
(албан тушаал, овог нэр)

Үйлдвэрийн № : _____ үйлдвэрлэсэн он: _____

(тоног төхөөрөмжийн нэр)

Ашиглалтын явцад дараах дүгнэлтийг гаргав:

Хийсэн ажил	Дүгнэлт
1. Тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтүүд ИКАО-гийн шаардлага болон үйлдвэрийн баримт бичгийн дагуу тохирч хангаж байгаа эсэх	
2. Тус төхөөрөмж нь байнгын зориулалтын (байнгын буюу түр)	
3. Иргэний агаарын тээвэрт мөрдөгдөж буй цахилгаан холболтын шаардлагыг хангасан эсэх	
4. Дараах шаардлагуудыг хангасан эсэх Хөдөлмөр хамгаалал Галын аюулгүй байдал Эрүүл ахуй	Тийм Үгүй Тийм Үгүй Тийм Үгүй
5. Антены байгууламж байрласан суурь (шороон, төмөр гэх мэт) Антены өндөр	
6. Тоног төхөөрөмжийн байршил нислэгт саад болох эсэх	
7. Тоног төхөөрөмжийн нийт өртөг үнэ	
Тодорхойлолт	
Тоног төхөөрөмж нь ашиглалтад тэнцэх эсэх	

Комиссын дарга:

_____ (албан тушаал, нэр, гарын үсэг)
Тамга
Гишүүд
_____ (албан тушаал, нэр, гарын үсэг)
_____ (албан тушаал, нэр, гарын үсэг)
_____ (албан тушаал, нэр, гарын үсэг)
_____ (албан тушаал, нэр, гарын үсэг)

20 оны сарын өдөр

Албан зориулалттай	Дүгнэлт (ИНЕГ гаргана)
Тоног төхөөрөмжийн ашиглах "Гэрчилгээ" олгоход татгалзах зүйлгүй (тохирохгүй тул олгох боломжгүй - шалтгааныг заах)	

..... (гарын үсэг).....(овог нэр)
20 оны сарын өдөр

ШАЛГАЛТ ТОХИРУУЛГЫН АЖЛЫН ҮР ДҮНГИЙН ХУУДАС

Захиалагч байгууллагын нэр			
Хэмжилт хийсэн огноо			
Хэмжих хэрэгсэл (Объект)-ийн нэр			
Хэмжих хэрэгсэл (Объект)-ийн серийн дугаар			
Шалгалт тохируулга (хэмжилт) хийх стандарт (арга аргачлал)-ын дугаар	Үйлдвэрлэгчийн заавар, ОХЗЛ-ийн 00408110602 журмын дагуу		
Шалгалт тохируулга (хэмжилт) хийсэн нөхцөл	t =°C	H = ...%	P =гПа

Шалгалт тохируулга хийхэд ашигласан эталон тоног төхөөрөмж.

Нэр	Маяг	Хэмжлийн хязгаар	Нарийвчлал	Серийн дугаар
Термометр	HMP41/45	-39.2 - +60°C	±0.2°C	Y2040029
Чийгшил тодорхойлогч	HMP41/45	0.8 - 100%	±2%	Y2040029
Барометр	PTB220A	50 - 1100 гПа	±0.2гПа	Y222003

Шалгалт тохируулга хийгдсэн хэмжих хэрэгсэл. [S/N:

Нэр	Маяг	Харьцуулалтаар тогтоогдсон алдаа	Зөвшөөрөгдөх алдаа
Термометр	HMP35		± 0.2°C
Чийгшил тодорхойлогч	HMP35		± 2%
Барометр	PTB200		± 0.2гПа

1. Гадаад үзлэг

Комиссын дарга:

Тамга
Гишүүд

	(албан тушаал, нэр, гарын үсэг)
	(албан тушаал, нэр, гарын үсэг)
	(албан тушаал, нэр, гарын үсэг)
	(албан тушаал, нэр, гарын үсэг)
	(албан тушаал, нэр, гарын үсэг)

20 оны сарын өдөр

Албан зориулалттай	Дүгнэлт (ИНЕГ гаргана)
Тоног төхөөрөмжийн ашиглах "Гэрчилгээ" олгоход татгалзах зүйлгүй (тохирохгүй тул олгох боломжгүй - шалтгааныг заах)	

..... (гарын үсэг).....(овог нэр)

20 оны сарын өдөр



МОНГОЛ УЛСЫН
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

№ _____


1. Тоног төхөөрөмжийн маяг, загвар _____

2. Үйлдвэрийн болон серийн дугаар _____
3. Хүчин чадал, ажиллах давтамж _____
4. Зориулалт _____
5. Байршил _____
6. Тус Гэрчилгээ нь дээр дурьдсан тоног төхөөрөмжүүдийг Агаарын навигацийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх тоногслал болохыг гэрчилэн бүртгэлжүүлнэ.
7. Энэхүү Гэрчилгээ нь _____ оны _____ сар _____ өдөр хүртэл буюу нийт _____ цагийн хүчинтэй байна.

Олгосон он, сар, өдөр _____

тэмдэг

Олгосон албан тушаалтан _____ / _____ /





МОНГОЛ УЛСЫН
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТАНД ТЭНЦЭХ
ГЭРЧИЛГЭЭ

№ _____

1. Тоног төхөөрөмжийн маяг, загвар _____

2. Үйлдвэрийн болон серийн дугаар _____

3. Хүчин чадал, ажиллах давтамж _____

4. Зориулалт _____

5. Тус Гэрчилгээ нь дээр дурьдсан тоног төхөөрөмжийг Иргэний нисэхийн дүрэм
_____ -ийн дагуу шаардлага хангаж ашиглалтад тэнцэж
байгааг гэрчилнэ.

6. Энэхүү Гэрчилгээ нь _____ оны _____ сар _____ өдөр хүртэл буюу нийт _____ цагийн
хүчинтэй байна.

тэмдэг Олгосон он, сар, өдөр _____

Олгосон албан тушаалтан _____ / _____ /

СУНГАЛТ

Хүртэл _____ хүчинтэй

тэмдэг

Гарын үсэг _____

Хүртэл _____ хүчинтэй

тэмдэг

Гарын үсэг _____

Хүртэл _____ хүчинтэй

тэмдэг

Гарын үсэг _____

Хүртэл _____ хүчинтэй

тэмдэг

Гарын үсэг _____